



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/04

Дэлгэрмөрөн

「Сар шинийн амралтын өдрүүдэд албаны
бэлэн байдлыг хангах арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сар шинийн амралтын өдрүүдэд 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 10:00 цагаас 2022 оны 02 дугаар сарын 06-ний өдрийн 23:00 цаг хүртэл албаны бэлэн байдлыг ханган ажиллах ажилтан, жижүүрүүдийг томилон ажиллуулахыг байгууллагын дарга эрхлэгч нарт

2. Дээрх өдрүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, яаралтай түргэн тусламж үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж албаны өндөржүүлсэн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төв (М.Дорждагва)-д,

3.Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн цагийн байдал үүссэн нөхцөлд ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг авран хамгаалах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (С.Нархүү)-д

4.Нийтийн хэв журам сахиулах, осол гэмтлээс хамгаалах, иргэдийн согтууруулах ундааны хэрэглээ, замын хөдөлгөөний хяналт, иргэдийн хэт бөөгнөрөлд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Ц.Пүрэвдорж), Цагдаа (Б.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

Zahiramj -2022 on
84 101193